



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 14-ний өдөр

Дугаар 2024/4


Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 сарын 14-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдаагүй тайланд тусгагдсан цэвэр ашгийн дүнгээс 37.5% (гучин долоо аравны таван хувь)-иар буюу 1,019,200,000 (нэг тэрбум арван есөн сая хоёр зуун мянга) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 2.8 (хоёр аравны найм) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуй нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 07 сарын 04-ний өдөр тараасугай.
4. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд танилцуулсугай.
5. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ